

Боловсрол, соёл, урлагийн газрын 7 хоногт
хийсэн ажлын мэдээлэл
/ III/08 – III/14 /

2019.03.14

№	7 хоногийн товч мэдээ	Дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	Бусад асуудал
1	Аймгийн ЗДТГ болон Боловсрол, соёл, урлагийн газраас зохион байгуулж буй “Элсэлтийн ерөнхий шалгалт-2019” аяны нээлтийн ажиллагааг 2019 оны 3 дугаар 14-ний өдөр аймгийн ХДТ-т аймгийн төвийн бүх ерөнхий боловсролын сургуулийн захирал, менежер, 12-р анги удирдсан багш, сурагчдыг хамруулан хийсэн. Тус аяны нээлтийн үйл ажиллагаанд Аймгийн засаг дарга А.Гылымхан, БСУГ-ын дарга Х.Зауре, БСУГ-ын МАЗН-ийн дарга А.Еркегүл, БСУГ-ын мэргэжилтэн Х.Азатбек, Дарын цогцолбор сургуулийн захирал Ш.Самат, Баян-Өлгий аймаг дахь Монгол банкны захирал М.Серёжа нар оролцож багш, сурагчдад зөвлөгөө өгсөн.		
2	Наурызын баярыг угтаж Өлгий сумын ерөнхий боловсролын сургуулиудын дунд "Үлттук өнөр - Асыл мұра" аймгийн уралдааныг 2 дахь жилдээ амжилттай зохион байгуулж, казах ардын зан үйл, ёс заншил, язгуур урлагийг сурталчилсан.		
3	УИХ – ын гишүүн, Барилга хот байгуулалтын сайд Х.Баделханы дэмжлэгээр Улаанбаатар хотын Цахим сорилго ХХК, аймгийн БСУГазар хамтран Өлгий сумын нийт 12 дугаар анги төгсөгчдөөс 10 хичээлээр сорилго шалгалтыг авах ажлыг зохион байгуулсан.		
4	Сумдын соёлын төвийн ажилтнуудын “Наурыз әуен” теле нэвтрүүлгийг “Дербес” телевизтэй хамтран зохион байгуулсан. /Одоогоор 8 сум хамрагдсан, Наурызын баярыг хүртэл үргэлжлэх болно/		

2019 ОНЫ 3 ДУГААР САРЫН 1-НИЙ ӨДРИЙН АЙМГИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ
ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

№	Өгөгдсөн үүрэг даалгаврын товч агуулга	Хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтан	Биелэлт
1	Цаг агаар дулаарч эхэлсэнтэй холбогдуулан аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудад холбогдох газруудыг хуваарилж өгч цэвэрлэгээ хийлгэх, хяналт тавьж ажиллах	7 хоног	Өлгий сумын Засаг даргад	
2	Аймгийн хэмжээнд 1-10 м гүнтэй худгаар ундны усны хэрэгцээгээ ханган хөрсний усыг ашиглаж буй 23 сургууль, цэцэрлэгийг цаашид цэвэр усанд холбох, эсхүүл стандартын шаардлага хангасан гүний худагтай болгох асуудлыг мэргэжлийн байгууллагууд хамтран судалж дүгнэлт гаргах	7 хоног	Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга, МХГ-ын дарга, БСУГ-ын дарга, Өлгий сумын Засаг дарга, “Суат” ХХК-ийн захирал нарт	1.Сургууль, цэцэрлэгийн хэрэглэж байгаа ундны усны худгийг МХГ-ын холбогдох улсын байцаагчийн актаар хассан нөхцөл байдлыг БСШУСЯ-ны Ерөнхий боловсролын бодлогын газарт танилцуулаад байна. Эдгээр байгууллагад мэдээлэл хүргүүлж усны шинжилгээг эхний ээлжинд МХГ-т шинжилгээнд хамруулах зөвлөгөө өгсөн боловч лаац нь тайлагдаагүйгээс шинжилгээнд хамруулж чадаагүй. Одоогоор ундны усыг зөөвөрлөн хэрэглэж байна. 2.Олимпиад зохион байгуулж байгаа сургуулиудад зөвлөмж хүргүүлж чанартай зохион байгуулах талаар зөвлөгөө өгсөн. Санхүүтэй холбоотой асуудлыг манай байгууллага зохицуулах боломжгүй байна.
3	Хоолны хордлогод өртсөн 11 иргэний Баяннуур сумаас Улаанбаатар хот руу явсан шалтгааныг тодруулж, хотод	7 хоног	Аймгийн ЭМГ-ын даргад	

	гаргасан үзлэг-шинжилгээний дүнг аймгийн удирдлагуудад танилцуулах			
4	Аймгийн хэмжээнд мал ихээр хорогдож байгаатай холбогдуулан мэргэжлийн байгууллага хорогдсон малын устгалын ажлыг яаралтай зохион байгуулах, малын сэг зэмийг худалдан борлуулах асуудалд хориг тавьж ажиллах талаар сумдын байцаагч нарт үүрэг даалгавар өгч, сэрэмжлүүлэх	7 хоног	Аймгийн МЭГ-ын даргад	
5	Малын туранхай махыг авахаар зарлал өгч буй хүмүүстэй холбогдох байгууллагуудын төлөөллүүд уулзаж худалдан авч буй шалтгааныг тодруулах, малын сэг зэмийг худалдан борлуулахгүй байх талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр ард иргэдэд сэрэмжлүүлэг мэдээ өгөх		Аймгийн МХГ-ын дарга, ЦГ-ын дарга, МЭГ-ын дарга нарт	

Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөний үүрэг даалгаврын биелэлтийг ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст 2019 оны 3 дугаар сарын 14-ний дотор ирүүлнэ үү.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР